



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/191

Цагаан-Уул сум

**Хяналт тавьж, хүлээн авах комисс
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа сумын төвийн камержуулалтыг нэмэгдүүлэх, засварлах ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дарга: А.Энхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

Гишүүд: Г.Ууганбаяр (Жаргалант багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Эрдэнэчулуун (Байгаль орчны мэргэжилтэн)

2. Тодорхойлолтод заагдасны дагуу дээрх ажилд явцын хяналтыг чанартай тавьж тэмдэглэл хөтлөн хүлээн авч акт үйлдэн ажиллахыг ажлын хэсэг (А.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-т даагасугай.

ОРЛОГЧ ДАРГА



Н.АЛТАНБААТАР